



**ТАЛХ ЧИХЭР ХК**

ЭРҮҮЛ ХҮНС **1984** ТАНЫ СОНГОЛТ  
ОНООС

ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ  
ТАЙЛАН  
2023 ОН



# АГУУЛГА

## БИДНИЙ ТУХАЙ

01

- Компанийн ерөнхий мэдээлэл
- Компанийн түүхэн замнал
- Эрхэм зорилго, Үнэт зүйлс, Алсын хараа

## БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

02

- Бизнесийн үйл ажиллагаа /чанарын зорилт/
- Бизнесийн үйл ажиллагааны биелэлт
- Өдөр тутмын үйл ажиллагаа сайжруулалт
- Үйлдвэрлэл, Хүнсний аюулгүй байдал
- Брэнд хөгжүүлэлт

## САНХҮҮГИЙН ТАЙЛАН

03

- Хураангуй тойм

## ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

04

- Хүний нөөцийн бодлого
- Нийгмийн хариуцлага
- Бидний амжилт
- Бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөө /2024 он/





- Оноосон нэр: **“Талх Чихэр” ХК**
- Хэлбэр: **Нээлттэй хувьцаат компани**
- Регистрийн дугаар: **2074575**
- Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага: **Монголын хөрөнгийн бирж**
- МХБ-ийн хувьцааны бүртгэлийн ангилал: **I**
- Гаргасан нийт хувьцааны тоо, ширхэг: **1,023,703 ширхэг**
- Бизнесийн үндсэн үйл ажиллагааны салбар: **Хүнсний үйлдвэрлэл, худалдаа**

“Талх Чихэр” ХК өдгөө талх, талхан бүтээгдэхүүнийг 24 цаг тасралтгүй үйлдвэрлэх 6 шугам, нарийн боов үйлдвэрлэлийн 5 шугам, жигнэмэг, чихрийн шугам бүхий “Томбаг” ХХК, бялуу, бэйкери төрлийн нандин бүтээгдэхүүн үйлдвэрлэх “Хотол” бялууны үйлдвэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж, өдгөө 40 дэх жилтэйгээ золгож байна.

Энэ хугацаанд бид АНУ, БНЧУ, БНСУ, Итали, Франц, Герман Голланд, Испани, Финланд, Австари гэх мэт улстай гадаад харилцаагаа тэлж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бүрэн автомат тоног төхөөрөмж, урсгал шугамыг салбартаа нэвтрүүлж, 4000 гаруй хувьцаа эзэмшигчтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байгаа Монголын топ 100 аж ахуй нэгжийн нэг.



- БНСУ-ын Хүнсний бүтээгдэхүүн тээвэрлэх хөргүүртэй болон хөргүүргүй тээврийн хэрэгслийг нэвтрүүлж, Тайван улсын сахарын болон хатуу төрлийн жигнэмэгийн шугам ашиглалтад оруулав.
- Микробиологи, Химийн лабораторид шинэчлэл хийж, дугуй талх үйлдвэрлэх компьютерийн удирдлагатай иж бүрэн шугам ашиглалтад оруулав.
- Монгол Улсдаа анх удаа БНЧУ-ын Dvopak J4 зүссэн талхны шугамыг ашиглалтад оруулж, хэрэглээний шинэ соёлыг хэрэглэгчдэд нэвтрүүлж, түгээв.
- Гурил вакум орчинд тээвэрлэх тоног төхөөрөмжийг Герман, Украин улсад захиалж, хийлгэв.



- Улсдаа анх удаа бүрэн автомат талх савлагч төхөөрөмж суурилуулав.
- Итали улсын CANOL фирмийн Чаналгын бүтээгдэхүүний тос шүүгч бүрэн автомат урсгал шугамыг Монгол Улсдаа анх удаа суурилуулав.
- Гурил вакум орчинд хадгалах, дамжуулах Итали улсын CEP1 агуулах, ЧЕХ улсын TOPOS фирмийн зуурмаг зуураг автомат шугамыг угсарч, суурилуулав.
- Нарийн боовны савлах бүрэн автомат төхөөрөмжийг Итали улсын TECHNO-D компанид захиалж, угсрав.
- Франц улсын уламжлалт бүтээгдэхүүн болох багетийг салбартаа анх удаа үйлдвэрлэв.



- Итали улсын CEP1 компаниас 500тн гурил вакум орчинд хадгалах, дамжуулах, гадны биет орохоос сэргийлэх 4 дамжлагат соронзон шүүлтүүр бүхий иж бүрэн системийг угсарч суурилуулав.
- “Онцгой” брэндийн 6 нэр төрөл бүхий бүтээгдэхүүн, ХХААХҮЯ-ны “Шинэ нэр төрлийн шилдэг бүтээгдэхүүний шагнал”-ын эзэн болов.
- “Хотол” үйлдвэр ашиглалтад оров.
- “Khaan” брэндийн бургер, хотдог, чиабатта, сэндвичний талхыг зах зээлд нэвтрүүллээ.



- Өнөд оршихуйн дархлаа “Язгуур” брэндийн зүсэлттэй хэвийн боовыг үйлдвэрлэж эхлэв.
- Хөдөлмөр аюулгүй байдлын менежментийн тогтолтоо ISO 45001:2018 стандартын тогтолцоог нэвтрүүллээ.
- Шилдэг 100 аж ахуй нэгжээр “Талх Чихэр” ХК дахин тодорлоо.
- Амьд хөрөнгөний талх, бэйкери төрлийн бүтээгдэхүүн худалдаалах “BAKING HOUSE”-ийн анхны салбараа нээж, өөрөө өөртөө үйлчлэх үйлчилгээний шинэ соёлыг амжилттай нэвтрүүллээ.
- “Сорилт, шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих шаардлага MNS ISO 17025:2018” стандартыг давтан магадлан баталгаажуулалт хийлгэв.

1984

2003-2008

2010-2012

2013-2014

2015-2017

2018-2020

2021-2022

2023


Иноваци ба хөрөнгө оруулалтын он жилүүд

Хэрэглээний соёлыг түгээж, хэрэглэгчдийн хандлагыг өөрчлөх

“Талх чихрийн комбинат” нэртэйгээр үйл ажиллагаагаа эхлүүлж хоногт 90тн талх, 5000тн чихэр, 6000тн жигнэмэг, өрмөнцөр, 800тн жимсний чанамал үйлдвэрлэж эхлэв.



- Нарийн боовны үйлдвэрлэлийн техник технологийг БНЧУ, Голланд улсын иж бүрэн тоног төхөөрөмжөөр шинэчлэв.
- “Та Чи”, “Органик” брэндийн зохицуулах үйлчилгээтэй нарийн боов шинээр худалдаанд худалдаанд гаргаж, эрүүл мэндэд тустай бүтээгдэхүүний хэрэглээний соёлыг хэрэглэгчдэд амжилттай нэвтрүүлсэн.
- “Та Чи” 4 төрлийн баяжуулсан талхны урсгал шугам суурилуулав.



- Орос технологийн Бородино талх болон сэндвич, бургерийн талхыг шинээр худалдаанд нэвтрүүлэв.
- Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 стандартыг салбартаа анх удаа нэвтрүүлэв.
- Талх, нарийн боовны үйлдвэрт тус бүр 30.000м<sup>2</sup> бүрэн автомат агааржуулалтын системийг суурилуулав.
- Ази тивд анх удаа БНЧУ-ын J4 компанийн хоёр давхар пийшинтэй талхны иж бүрэн урсгал шугам ашиглалтад оруулав.
- Хүнсний аюулгүй байдлын тогтолцооны ISO 22000:2018 стандартыг салбартаа анх удаа нэвтрүүллээ.



- Өрх тусгаар залуу гэр бүлд зориулсан жижиг хэмжээтэй “Өв соёл” хэвийн боовыг зах зээлд амжилттай нэвтрүүлэв.
- Олон улсын эмэгтэйчүүдийн баярыг тохиолдуулан 3м өндөр, хагас тонн жинтэй ХОТОНД баялууг урлав.
- DELICE PASTRY брэндийг зах зээлд нэвтрүүлэв.
- “Онцгой” олон үртэй талх “Ард түмний хүнс”-ээр шалгарлаа.
- “Khaan” брэндийн “Чиабатта” талх нь “ШИНЭ ШИЛДЭГ БҮТЭЭГ ДЭХҮҮН”-ээр шалгарлаа.
- ISO 9001:2015 стандартын давтан баталгаажуулалтад амжилттай орж, гэрчилгээг гардан авлаа.
- ISO 22000:2018 Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцооны стандартын магадлан баталгаажуулалтыг амжилттай хийлгэв.







## ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид олон улсын чанарын стандартад нийцсэн дэвшилтэт технологиор бүтээгдэхүүнээ үйлдвэрлэн зах зээлд нийлүүлж, хэрэглэгч харилцагчдынхаа сэтгэл ханамжинд үнэлэгдсэн хүнсний салбарын загвар компани байна.

## АЛСЫН ХАРАА

Хувьсан өөрчлөгдөх хэрэглээний соёлыг тодорхойлон, стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийгэмд үнэ цэнэ бүтээгч, хүн төвтэй байгууллага байна.

## ҮНЭТ ЗҮЙЛС


**Т** - Тэргүүн технологи  
**А** - Аюулгүй бүтээгдэхүүн  
**Ч** - Чадварлаг ажилтан  
**И** - Итгэлцэл, түншлэл



# БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Талх Чихэр” ХК нь Чанарын менежментийн тогтолцооны хүрээнд хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээдлэн, сонирхогч талуудын хэрэгцээ шаардлагыг хангаж, хүнс үйлдвэрлэлийн хэлхээний бүхий л үе шатанд эрүүл ахуй, үйлдвэрлэлийн зохистой дадлыг мөрдөж, хэрэглэгч болон харилцагчдад чанартай, аюулгүй бүтээгдэхүүн, үйлчилгээг тогтвортой үзүүлж, үйл ажиллагаандаа байнгын сайжруулалт хийх хэрэгжүүлэх зорилгоор бизнесийн үйл ажиллагаагаа төлөвлөн ажиллаж байна.

2023 онд бид бүтээгдэхүүний борлуулалт, түгээлтийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор маркетинг менежемент, борлуулалтын чадварлаг баг бүрэлдэхүүнтэйгээр трейдинг хэлбэрийн үйл ажиллагааг туршиж, ажиласан нь өдөр тутмын үйл ажиллагааг хөнгөвчилж, олон давуу тал бий болсон байна.







## ИННОВАЦИЙН ХӨГЖИЛ УДИРДЛАГЫН СТРАТЕГИ ЧАНАРЫН ЗОРИЛТ

“ISO 22000:2018” ХАБМТ-ны стандарт дээр тулгуурлан үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулах зорилгоор “FSSC 22000” – хүнсний аюулгүй байдлын схем, хүнсний чанар, хүнсний хамгаалалт, хуурамч бүтээгдэхүүнээс сэргийлэх ажиллагааг хамарсан иж бүрэн менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлж, баталгаажуулалт үнэлгээг хийлгэнэ.

“MNS ISO 45001:2018” ХЭМАБМТ-ны стандартын үнэлгээ, баталгаажуулалтыг хийлгэж, үйл ажиллагаандаа нутагшуулан, сургалт хөгжүүлэлтийг тогтмолжуулж, гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт /KPI/-р үнэлэх системийг сайжруулна.



FSSC 22000 – Хүнсний аюулгүй байдлын баталгаажуулалтын иж бүрэн тогтолцооны стандартыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхээр зорилтыг тавьж, 2023 оны 03 сараас эхлэн баг бүрдүүлэн, FSSC 22000-ийн сургалтанд хамрагдаж, сертификат авсан.

2024 онд “FSSC 22000”-ийн нэвтрүүлэн хэрэгжүүлэх, баталгаажуулах ажлуудыг эхлүүлэхээр төлөвлөгөө гарган ажиллаж байна.

ISO 45001:2018 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын стандартын баталгаажуулалтыг 09 сард аудитад амжилттай баталгаажуулалт хийгдэж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, байнгын сайжруулалт хийж байна.

Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдал, орчин нөхцлийг сайжруулан мэргэжлийн байгууллагаар Хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээг хийлгэж, төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна.







## ЗАХ ЗЭЭЛИЙГ ӨРГӨЖҮҮЛЭХ, БРЭНДИЙГ ХӨГЖҮҮЛЭХ

ЧАНАРЫН ЗОРИЛТ

*Бялуун төрлийн бүтээгдэхүүний шинэ хэрэглээ бий болгож, Хэвтэй талхны шугамыг бүрэн автоматжуулан хүчин чадал болон нэр төрлийг 30-40%-иар, Давхраат болон Хөөмөл бүтээгдэхүүний нэр төрлийг 50%-иар, Монголын үндэсний тавгийн идээний боовны нэр төрлийг 10%-иар тус тус нэмэгдүүлнэ.*



2023 оны 05 сарын 20-29 хооронд 12 хүний бүрэлдэхүүнтэй баг Шанхай хотод зохион байгуулагдсан “Bakery China” үзэсгэлэнд оролцож, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, тоног төхөөрөмж, өнөөгийн чиг хандлага, түүхий эдийн чанарыг сайжруулах боломжийг судалж, энэхүү чиглэлийн ханган нийлүүлэгч байгууллагуудтай гэрээ хийн, хамтран ажиллаж байна

Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн хөгжлөөр тэргүүлсээр байгаа олон улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйлдвэрлэлийг эх орондоо нэвтрүүлэх зорилгоор ХБНГУ-ын Мюнхен хотод болсон “IBA-2023” үзэсгэлэнд оролцов.

Франц амтыг мэдрүүлсэн “Круассан”-ийг Европын техник, технолгиор үйлдвэрлэн хэрэглэгчдэд хүргэж байна. Бүрэн автоматжуулсан сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр 10 нэрийн давхраат болон хөөмөл бүтээгдэхүүнийг зах зээлд худалдаанд гаргаж борлуулалтын сувгийг тэлсэн.







## ЗАХ ЗЭЭЛИЙГ ӨРГӨЖҮҮЛЭХ, БРЭНДИЙГ ХӨГЖҮҮЛЭХ

ЧАНАРЫН ЗОРИЛТ

*Техник, тоног төхөөрөмжийн засварын нөөц бүрдүүлж, мэдээллийн сан үүсгэх, уламжлалт чаналгын бүтээгдэхүүний үндсэн дамжлага (хэвлэгээ, бэмбий)-г механикжуулж, гар ажиллагааг 20%-иар багасгах, “Багет”, “Чиабатта” талхны шугамыг бүрэн автоматжуулан хүчин чадлыг нэмэгдүүлнэ.*

Үйлдвэрийн тасралтгүй үйл ажиллагааг сайжруулж, хангахын тулд тоног төхөөрөмжийн засварын нөөц бүрдүүлэн, Итали, БНХАУ-ийн дэвшилтэт тоног төхөөрөмж үйлдвэрлэдэг байгууллагуудтай хамтарч, тоног төхөөрөмжийн шинэчлэлт сайжруулалт хийсэн.

Итали улсад зохион байгуулсан “Siger” үзэсгэлэнд оролцож Ceri, Costal, Beor, зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ хэлэлцээр хийн, тоног төхөөрөмжийн захиалга хийгдсэн. Ингэснээр Costal-ийн эхний ээлжийн тоног төхөөрөмж ирж, туршилт тохируулгын ажлууд хийгдлээ. Мөн Итали улсын Logidice, Itac пийшин, босголтын шкафын угсралт тохируулга хийгдсэн байна.

Beor компани гэрээний дагуух тоног төхөөрөмжийн программ суулгалт, туршилт, тохируулгыг бэлтгэж байна. (Beor тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгчийн бэлтгэл ажлын гүйцэтгэл 90%-тай явж байна.)

Механик цехийн тоног төхөөрөмж, гурилын системийг сайжруулах судалгаа хийж, Тайвань улсын дэвшилтэт тоног төхөөрөмж үйлдвэрлэдэг SRON-байгууллагын үйл ажиллагаатай танилцан туршлага судалж, Силосны системийн төслийн ажлуудыг хэрэгжүүлж эхэлсэн.

Үйлдвэр, Оффис, Лабораторийн агааржуулалтын системүүдийг сайжруулах зорилгоор БНХАУ-н Hisense компанитай хамтран ажиллах гэрээг хийж, мэргэжилтэнг урьж, агааржуулалтын систем дээр сайжруулалт хийж эхэлсэн. (агааржуулалтын систем гүйцэтгэл -80% -тай явж байна.)





## ЗАХ ЗЭЭЛИЙГ ӨРГӨЖҮҮЛЭХ, БРЭНДИЙГ ХӨГЖҮҮЛЭХ

ЧАНАРЫН ЗОРИЛТ

*Сонирхогч талууд болон хэрэглэгчийн сэтгэл хангамжийн хэрэгцээ, шаардлагыг судлан, сэтгэл ханамжийн түвшин 8%-иар дээшлүүлж, Зах зээлд шинээр нийлүүлсэн бүтээгдэхүүний борлуулалтыг 10%-иар өсгөнө.*



ХХААХҮ-ийн салбар дахь төр, хувийн хэвшлийн хамтыг ажиллагааг сайжруулах зорилгоор жил бүр зохион байгуулагддаг “Намрын ногоон өдрүүд” нэгдсэн арга хэмжээ 18 дахь жилдээ амжилттай оролцлоо.



БНХАУ-д зохион байгуулагддаг Хятад-Монголын 4 дэх удаагийн ЭКСПО-д “Талх Чихэр” ХК талх, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбараа төлөөлөн оролцлоо.



Стандарт, хэмжил зүйн газрын 100 жилийн ойн хүрээнд Сүхбаатарын талбайд зохион байгуулагдаж буй “Иргэдэд ээлтэй стандарт” өдөрлөгт амжилттай оролцов.



Амьд хөрөнгөний талх, бэйкери төрлийн бүтээгдэхүүн худалдаалах, өөртөө үйлчлэх “BAKING HOUSE” инсторийн 2 салбарын үйл ажиллагааг эхлүүллээ.



Үндэсний үйдвэрлэгчдийн “Баялаг бүтээгч-Business” тур 4 дэх удаагийн арга хэмжээний хүрээнд 50 гаруй үндэсний үйлдвэрлэл эрхлэгчдийн төлөөлөл “Талх Чихэр” ХК-ийн үйл ажиллагаатай танилцлаа



“Convenience store”-ийн салбарт бүтээгдэхүүн үйлчилгээгээ нэвтрүүлэх, борлуулалтын сувгаа тэлэх зорилгоор тухайн салбарт ажиллаж байгаа төлөөллүүдтэй биелэн уулзалт хийж, өөрсдийн бүтээгдэхүүн үйлчилгээг танилцууллаа





## Талхны зах зээл

Талхны үйлдвэр нь 24 цагийн турш үйлдвэрлэх 6 шугамаар 12 брэндийн нэрийн дор 44 нэр төрлийн талх үйлдвэрлэж байна. Талхны зах зээлд жижиглэн үйлдвэрлэлийн өрсөлдөөн нэмэгдэж байгаа ч хэрэглэгчийн хэрэгцээ сонирхолд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх тал дээр онцгой анхаарч, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэвийн жигд, тогтмол байлгах зорилгоор хүний нөөц, түүхий эд материал, технологи арга барил, тоног төхөөрөмж зэргээр инноваци шинэчлэлийг тасралтгүй хийж байна.





## Нарийн боовны зах зээл

Нарийн боовны үйлдвэр нь 4 шугамаар “Та Чи”, “Онцгой”, “Delice Pastry” гэсэн брэндийн нарийн дор 46 нэр төрлийн нарийн боов үйлдвэрлэж байна. Нарийн боовны зах зээлийн хувьд хэрэглэгчдийн хандлага өөрчлөгдөж, шинэлэг байдлаар худалдан авах сонирхол нэмэгдэж байгаа. Тиймээс бид хөлдөөсөн бүтээгдэхүүний туршилт, тохируулгын ажлыг амжилттай гүйцэтгэсэн бөгөөд харилцагч байгууллагуудаа хөлдөөсөн бүтээгдэхүүнийг нийлүүлэх ажлыг эхлүүлээд байна.





## Бялуу бэйкери зах зээл

“Талх чихэр” ХК-ийн “Хотол” бялууны үйлдвэр 62 төрлийн бялуу, 32 нэр төрлийн бэйкери төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Бялуу, бэйкери төрлийн бүтээгдэхүүний зах зээлийн хувьд баярын уур амьсгалыг илэрхийлдэг онцгой бүтээгдэхүүн. Иймээс бид онцлох баярт зориулсан онцгой загварын бялууг хэрэглэгчдэд санал болгож, “Хотол” үйлдвэрийн бялууг худалдан авах сувгийн хүрээг тэлж, хэрэглэгчид ойртуулах ажилд онцгой анхаарч ажилласан. Мөн хувьсан өөрчлөгдөж буй хэрэглэгчийн хэрэглээнд нийцүүлж, илүү амтлаг, жижиг хэмжээтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэн, илүү сонголттойгоор шинээр худалдаанд гаргасан.

MNS ISO 17025:2018  
ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



“Талх Чихэр” ХК-ийн хэмжээнд төв лаборатори болон үйлдвэрийн дотоод лаборатори гэсэн хоёр лаборатори байдаг. Төв лаборатори нь Хими болон Микробилогийн шинжилгээг өдөр бүр сорьц аван шинжилж байна. “Сорилт, шалгалт тохируулгын лабораторийн чадвахид тавих шаардлага” MNS ISO/IEC 17025:2018 стандартыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажилладаг.

Үүнд:

- Шинжилгээний хамрах хүрээг өргөтгөн Химийн лабораторид Усны хатуулагийн шинжилгээг хийж байгаа бол Микробилогийн лабораторид бактерийн шинжилгээг усны дээж болон түүхий эдэд хийж байна.
- Лабораторийн ажилчдын ур чадварыг сайжруулах, мэргэшүүлэх зорилгоор дотоод, гадаадын сургалт хөтөлбөрт түлхүү хамруулж ажиллав.
- Эрүүл аюулгүй, чанартай хүнс үйлдвэрлэхийн тулд лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлж, орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмж, лабораторийн орчин нөхцөл агааржуулалтын системийг сайжруулав.



## Програм нэвтрүүлэлт

Борлуулалт, түгээлтийн өдөр тутмын үйл ажиллагааг хөнгөвчилж, ажилчдын тухтай ажиллах боломж нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор агуулах болон борлуулалтын үйл ажиллагааг хөнгөвчлөх програмыг шинэчлэн нэвтрүүллээ. Ингэснээр борлуулагч болон агуулахын хоорондын өдөр тутмын үйл ажиллагаанд:

- Албад хоорондын мэдээлэл солилцох ажил хөнгөвчлөгдөж
- Нэмэлт борлуулалт хийх
- Борлуулалтын захиалгаа хялбар аргаар өгөх

зэрэг олон талын давуу тал бий болсон байна.




## Хэрэглэгчийн утас

Хэрэглэгчийн санал хүсэлт, гомдлыг түргэн шуурхай хугацаанд шийдвэрлэх нь байгууллагын алсын хараа, стратегийн хувьд томоохон байр суурь эзэлдэг. 2023 оны байдлаар санал хүсэлтийн утсанд 2600 гаруй дуудлага ирсэн байна. Хэрэглэгчийн утсанд ирсэн нийт санал гомдлыг өмнөх онтой харьцуулахад 26,7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хэрэглэгчийн сэтгэл хангамжийн түвшинг өмнөх оныхтой харьцуулахад 1%-иар өссөн үзүүлэлттэй байна.



“Талх Чихэр” ХК-ийн брэнд бүтээгдэхүүн бүр хэрэглэгчийн хэрэгцээ шаардлага, хүсэл сонирхолд нийцсэн байдаг. Тэр ч утгаараа бид хэрэглэгчийн сегмент бүрд тохирсон брэндийн идэвхжүүлэлтийн ажлыг сошиал маркетингийн суваг ашиглан хийж, бүтээгдэхүүнтэй холбоотой мэдээ мэдээллийг хүргэн ажиллаж байна.



45%

55%

АТАР МИШЭЭЛ ҮРГАЦ





## ЯЗГУУР БРЭНД

“Талх Чихэр” ХК нь “Атар” брэнд, “Түмэн насан” брэнд, “Өв соёл” хэвийн боовыг үйлдвэрлэн худалдаанд гаргасан. 2023 онд “Өв соёл” хэвийн боовыг гол бүтээгдэхүүн болгон хэрэглэгчдэд өв уламжлалаа хадгалан үлдэх, өрх тусгаар залуу гэр бүл идээ засах ёс уламжлалыг уриалан маркетингийн идэвхжүүлэлтээ хийн ажилласан. Жил бүр уламжлал болгон “Атар” хэвийн боовны нэрэмжит улс, аймгийн цолтой 256 бөхийн барилдаан, хэвийн боовны үйлдвэрлэлийн нээлт зэрэг эвент арга хэмжээг зохион байгуулхаас гадна олон үзэсгэлэн худалдаанд оролцож, хэрэглэгчдэд шууд хүрэх борлуулалтын сувгуудаар амжилттай хүргэж ажиллаа.

Мөн хэрэглэгчийн хэрэгцээ сонирхолд нийцүүлэн “Язгуур” брэндийн зүсэлттэй хэвийн боовыг анх удаа худалдаанд гаргасан бөгөөд даллага авахуулах, буян хишгээ арвижуулахад онцлон хэрэглэдэг “Тавжийн дугуй”-г хүнсний аюулгүй байдал хангасан орчинд үйлдвэрлэн хэрэглэгчдэдээ хүргээд байна.





## ХОТОЛ БРЭНД

“Хотол” бялууны үйлдвэр нь амтат бялууг баяр бүрийн гол амттан байлгах үүднээс тусгай загвар, чимэглэлтэйгээр үйлдвэрлэж байгаа. Бялуу гэдэг бүтээгдэхүүн өөрөө ямар ч онцлох баярыг илэрхийлэх онцгой бүтээгдэхүүн юм. Иймээс бид баяр бүрийг онцгой хэмээн үзэж, тухайн баярт зориулан онцгойлон чимэглэл хийж, маркетингийн идэвхжүүлэлтээр дамжуулан хэрэглээний соёлыг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Мөн хуримын бялууны загвар чимэглэлд онцгой ач холбогдол өгөн, жил бүр зохион байгуулдаг “Wedding Expo-2024”-т 2 дахь жилдээ амжилттай оролцсон.

Монголд бялуу, бялуун төрлийн бүтээгдэхүүний эрэлт хурдацтай өсөн нэмэгдэж байна. Тийм ч учраас нарийн мэдрэмж, технологи ажиллагаа, эрүүл ахуйн өндөр хяналт шаардсан бялуу, бэйкери төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх тал дээр онцгой ач холбогдол өгөн ажиллаж байна.

Бид түүхий эд болон бүтээгдэхүүний судалгаа, хөгжүүлэлтийн үндсэн дээр өнөөдөр 62 нэр төрлийн бялуу 32 төрлийн бэйкери бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байна.





# ТА ЧИ БРЭНД



“Та Чи” брэндийн нэрийн дор бид 30 орчим нэр төрлийн давхраат, хөөмөл, мөөхий төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Улаанбаатар хотын хэмжээнд бид нарийн боовны зах зээлийн 20 гаруй хувийг эзэлж байна.



“Та Чи” брэндийн хувьд бид давхраат, хөөмөл, мөөхий, чаналгын гэсэн 4 төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бөгөөд бүтээгдэхүүний чанар, нэр төрлийг нэмэх тал дээр онцгой анхаарч ажилласан.

Онцлон дурдвал хэрэглэгчийн таашаалд хэдийн нийцсэн “Аяны боорцог”-ийн төрлийг нэмж, “Бүхэл үрийн Аяны боорцог”-ийг худалдаанд амжилттай нэвтрүүлээ.






# DELICE PASTRY



## БРЭНД

2022 онд удаан хугацааны туршилт судалгаа, хамтын ажиллагааны үндсэн дээр “DELICE PASTRY” брэндийг зах зээлд амжилттай нэвтрүүлсэн. Төлөвлөгөөний дагуу 2025 он хүртэл тус брэндийн нэвтрэлтийн үе шат учраас бүтээгдэхүүн хөгжүүлэлт, маркетинг идэвхжүүлэлтэд онцгой ач холбогдол өгөн ажиллаж байна.




Анх бид 20 нэр төрлийн бүтээгдэхүүн худалдаанд гаргаж байсан бол хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа, шинжилгээнд тулгуурлан 2023 онд 10 нэр төрлийн бүтээгдэхүүнийг шинээр худалдаанд гаргасан.



# BAKING HOUSE

Нийгмийн чиг хандлага өөрчлөгдөж, хэрэглэгч эрүүл мэндэд тустай бүтээгдэхүүн түлхүү сонгон хэрэглэх сонирхолтой болсон. Иймээс “Талх Чихэр” ХК амьд хөрөнгөний шинэхэн талх, бэйкери төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, “BAKING HOUSE”-ийн инсториин 2 салбараа Emart Баянгол салбар болон Номин Хурд хорооллын салбарт амжилттай нээлээ. Ингэснээр хэрэглэгч шинэ талхыг шаржигнасан, шинэлэг байдлаар сонгон авч, Хотол үйлдвэрийн бэйкери төрлийн бүтээгдэхүүнийг шууд худалдан авах боломжтой болсон билээ.

Уг инстори нээгдсэнээр бид хэрэглэгч өөрийн дуртай талхаа өөрөө сонгоод авах, өөрөө өөртөө үйлчлэх үйлчилгээний шинэ соёлыг нэвтрүүлж чадсан билээ. “BAKING HOUSE”-ийн инсториин 2 салбарт одоогийн байдлаар 30 гаруй төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн хэрэгчдэдээ хүргэж байна.





## ХААН БРЭНД

Зав чөлөө багатай энэ нийгэмд хэрэглэгчийн ажлыг хөнгөвчлөх өглөө, өдөр, оройн хоолыг хурдан хугацаанд хийж бэлдэх боломжтой. Иймээс бид “Khaan” брэндийн бүтээгдэхүүнээр дамжуулан “ХЭЗЭЭ Ч ХААНА Ч ӨӨРИЙНХӨӨРӨӨ” уриатай “Khaan” брэндийн нэрийн дор 4 нэр төрлийн бүтээгдэхүүнийг бид үйлдвэрлэж байгаа.

Уг ажлын хүрээнд өсвөр насны хүүхдүүдийн дунд шуугиан дэгдээн, трэнд бий болгож байсан “GIRLS” цувралын S3-ийг ивээн тэтгэж, охидын хамтын 2 дахь клип дээр хамтран ажилласан. Ингэснээр өсвөр насны хүүхдүүдийг өөрийн дуртай хоолоо хийх амархан гэх санааг өгөн ажилласан.

Мөн аялал зугаалгын улирал эхэлсэнтэй холбоотойгоор хаана ч өөрийнхөө дуртай хоолыг хийх боломжтой гэх хэрэглээний соёлыг зааж өгөн ажилласан байна.





**122,3 ТЭРБУМ**  
НИЙТ БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

**13,6 ТЭРБУМ**  
УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН  
ОРЛОГОД

“ТАЛХ ЧИХЭР” ХК

2023 онд 122,3 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, урьд оны энэ үеэс орлого 21,4 тэрбум төгрөгөөр буюу 21.3%-р өссөн байна. Улсад орлогын татвар 1,8 тэрбум төгрөг төлсөн. Монгол улсын нэгдсэн төсвийн орлогод 13,6 тэрбумыг төвлөрүүлсэн байна.



Нийт ажилтан


1081

49,6%  
эрэгтэй


50,4%  
эмэгтэй

2023 онд 137 ажлын байр нэмэгдсэн

НАСНЫ БҮТЭЦ



КОМПАНИД АЖИЛЛАСАН  
ЖИЛ





## СУРГАЛТ, ХӨГЖҮҮЛЭЛТ

Ажилчдыг сургаж хөгжүүлэх, мэргэшүүлэх үйл ажиллагааг дотоод нөөц бололцоогоор тогтмол хийж хэрэгжүүлсэн. Энэ хүрээндээ дотооддоо өөрсдийн нөөц бололцоогоор болон гадны мэргэжилтэн багш нарын оролцоотой сургалтад ажилчдаа хамруулан ажилласан.

### Дотоод:

- Галын аюулгүй байдал
- ISO 45001:2018 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын стандартыг нэвтрүүлэх
- ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо
- Гадаад мэргэжилтэн болон зөвлөх инженерийн технологи болон тоног төхөөрөмжийн сургалт,
- Тусгай ур чадвар олгох сургалт
- Хувь хүний хөгжлийн сургалт,
- Шинэ ажилтны танилцуулах сургалт
- Шинэ бүтээгдэхүүний танилцуулга сургалтыг тогтмол зохион байгуулсан.

### Гадаад:

- БНХАУ, Герман улсын (Angel , Гуагуажо, Фритч, Ирекс, Miwe)- тай хамтарч гадагшаа сургалтад мэргэшсэн технологич нарыг хамруулж мөн Монголд гаднын туршилагатай мэргэжилтэнүүдийг урьж практик сургалтад бүтээгдэхүүн хөгжүүлэлт технологийн сургалтад хамруулав.









## ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

Ажилтан бүрийг тогтвор суурьшилтай ажиллах боломж бүрдүүлэх үүднээс спортын тэмцээн, урлагийн наадам, аялал, шагнал урамшуулал зэрэг арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулан ажилласан. Үүнээс гадна ажиллах орчин нөхцлийг сайжруулах, урам зориг өгөх зорилгоор бүтээн байгуулалтын олон ажил зохион байгуулсан.

Эдгээрийг онцолбол:

- Цайны газрын тохижилт
- Ажилчдын амрах өрөөний тохижилт
- Эмнэлэгийн тохижилт, тоног төхөөрөмжийн шинэчлэл
- Борлуулагчийн амрах өрөө
- Баруун өргөтгөлийн бүтээн байгуулалт
- Event hall-ийн бүтээн байгуулалт





## EVENT HALL

2023 онд сонгодог загварын интерьер бүхий эвент халлыг ашиглалтанд орууллаа. Манай эвент халл нь нэг удаад босоогоор 200 хүн, суугаа байдлаар 100 хүн хүлээн авах хүчин чадалтай, 3 талд байрлах чанарын өндөр түвшинтэй лед дэлгэц, мэргэжлийн тогоочийн буфет хоол зэрэг онцлох үйлчилгээг бид нэг дор бүрдүүлж чадсан.

Мөн “Талх Чихэр” ХК-ийн 40 жилийн түүхэн ойг угтан компани анх шав тавьж байсан үеэс өнөөдрийг хүртэлх онцлох үйл явдлыг багтаасан “Талх чихрийн нэг өдөр” зургийг “Дэлхийн нэг өдөр” бүтээлээрээ олонд танигдсан зураач Н.Сэргэлэн бүтээв.







Бүх ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэндийн үзлэгийг хийж байна.



Мэргэжлийн байгууллагатай хамтран Анхан тусламжийн сургалт, дадлагыг зохион байгуулан бүх ажилчдад мэдлэг ойлголтыг өгч байна.



Нийгмийн хариуцлагын хүрээнд СХД-ийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин өөрийн байранд “ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА” зохион байгууллаа



Нийгмийн хариуцлагын хүрээнд олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан 900 гаруй ажилтан албан хаагчдынхаа хүүхдэд гэнэтийн бэлэг барьж, "Мөрөөдөл бидний ирээдүй-Та Чи" арга хэмжээг зохион байгууллаа



"Талх Чихэр" ХК-ийн үе үеийн алтан хэлхээ болсон ахмад ажилчдаа хүлээн авч, хүндэтгэл үзүүллээ.

“Талх Чихэр” ХК 40 жилийн ойн босгон дээрээ Улаанбаатар хотын ЗАА-тай хамтран хоёр дахь жилдээ зохион байгуулсан #САНТАТАЙ ШИНЭ ЖИЛ арга хэмжээ амжилттай болж өнгөрлөө.

Нийгмийн хариуцлагын хүрээнд Тээврийн цагдаагийн газраас зохион байгуулсан “Нэг зам Нэг соёл” аяныг дэмжин ажиллаж, амралт зугаалгын 1 сарын хугацаанд аяны стикерийг бүтээгдэхүүн дээр байршуулан ажиллав.

Нийгмийн хариуцлагын хүрээнд Монгол цэргийн өдөр, Орчин цагийн Зэвсэгт Хүчин үүсэн байгуулагдсаны 102 жилийн ойг угтан Зэвсэгт хүчний 120-р ангийн бие бүрэлдэхүүний төлөөлөл үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай танилцлаа

Монголын уртын дууны холбооны 20 жил, Уртын дууны “Өнө” чуулгын 10 жилийн ойг тохиолдуулан 300 уртын дуучин нэг дор чуулж, ургах нарыг уртын дуугаараа угтсан түүхэнд бичигдэх гайхалтай үйл явдлыг ивээн тэтгэв.

Жил бүрийн сар шинийн баярыг тохиолдуулан Монголын Хөдөлмөрийн баатруудын холбоотой хамтран "БААТРУУДААРАА БАХАРХЪЯ" хүндэтгэлийн хүлээн авалтыг 12 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа.

Сар шинийн баярыг угтан шинэ оны анхны хүчит бөхийн барилдаан “АТАР” хэвийн боовны нэрэмжит аймаг цэргийн цолтой хүчит 256 бөхийн барилдаан боллоо.





# АМТЛАГ АЯЛАЛ 2023

"Амтлаг аялал" нэрийн хүрээнд Улаанбаатар хотын 10 жилийн сургууль, хамтран ажиллагч байгууллагын 1000 гаруй хүүхэд багачуудад үйлдвэрийнхээ үйл ажиллагааг танилцуулсан байна. Аялалд оролцсон хүүхэд бүртээ бид #Амтлаг брэндийнхээ бүтээгдэхүүний дээжийг бэлэглэсэн билээ. Монголын ардчилсан холбоо, "Genco Tour Bureau" ХК-тай хамтран зохион байгуулсан аяллын хүрээнд Улаанбаатар хот, 21 аймгийн 300 гаруй хүүхэд багачууд үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай танилцсан.






# НОГООН БАЙГУУЛАМЖ

Нийгмийн хариуцлагын хүрээнд компанийн урд талд байрлах 726,3 м<sup>2</sup> талбайг зүлэгжүүлж, 50ш гоёлын мод болох голт бор, 10ш бүйлс, 9ш гацуур мод тарьж суулган, ногоон байгууламжийн ажлыг хийж гүйцэтгэв.

Мөн хавар, намрын улиралд цэвэрлэгээ, арчилгааг тогтмол хийж ажиллав.







Хүнс үйлдвэрлэлийн салбарт шинэлэг технологи, инноваци нэвтрүүлж, хүн ардаа эрүүл, аюулгүй хүнсээр хангахад манлайлан ажиллаж байгааг үнэлж, СХД-ийн ЗДТГ-аас "ТЭРГҮҮНИЙ ХУДАЛДАА ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭГЧ БАЙГУУЛЛАГА"-аар шалгарав.

"УРГАЦЫН БАЯР-2023" хүндэтгэлийн арга хэмжээний үеэр "Талх Чихэр" ХК ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ШИЛДЭГ ҮЙЛДВЭРЛЭГЧЭЭР шалгарлаа.



Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулсан оролцоогоороо үнэлэгдэн "ТОП-100 аж ахуй нэгж"-ээр дахин шалгарлаа







- “FSSC 22000”- Хүнсний аюулгүй байдлын схем, хүнсний чанар, хүнсний хамгаалалт, хуурамч бүтээгдэхүүнээс сэргийлэх ажиллагааг хамарсан иж бүрэн менежментийн тогтолцооны стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, хэрэгжүүлнэ.
- Байгууллагын соёл, хувь хүний хөгжил сэтгэл зүйн зан төлөвийн мэдлэг ойлголт, ур чадварыг нэмэгдүүлж үнэлэх, хөдөлмөрийг хөнгөвчлөх бүтээмжийг сайжруулах, “Казейн” саналыг дэмжин ажилтан бүрийн оролцоог нэмэгдүүлэх. Ажлын байрны орчин нөхцлийг сайжруулж, ажиллагсдын эрүүл мэнд, дархлааг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах.
- Техник, тоног төхөөрөмжийн засварын нөөц бүрдүүлж, мэдээллийн санг үүсгэх, ERP-программ нэвтрүүлэх. Талхны үйлдвэрийн “Ургац” шугамын тоног төхөөрөмжийг шинэчилж, механикжуулснаар гар ажиллагааг 70%-иар багасгах, “Чиабатта” шугамын хүчин чадлыг нэмэгдүүлэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийж, гар ажиллагааг 60%-иар багасгаж бүтээмжийг дээшлүүлнэ.
- Нарийн боовны үйлдвэрийн “Юнилайн” шугамын хөнтрөгч, босголтын шкаф, “Юнимакс” шугам, Хотол чаналгын үйлдвэрийн “Канол” шугамын хөргөлтийн конвейрийн дамжлагын хэсгүүдэд шинэчлэлт хийснээр хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, бүтээгдэхүүний технологи, чанар аюулгүй байдлыг дээшлүүлнэ.
- Сонирхогч талууд болон хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч, сэтгэл ханамжийн түвшинг 1,0%-иар, бүтээгдэхүүн үйлчилгээнээс хамаарсан санал гомдлыг 6%-иар буруулж, бодит бус гомдлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохих арга хэмжээг авч шийдвэрлүүлнэ.
- Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор борлуулалт, түгээлтийг тусгаарлах замаар өөрчилж, байгуулан ажиллана.
- “Талх Чихэр” ХК шинэ төсөл, хөтөлбөрүүдийг дэмжих зорилгоор гэрээний үндсэн дээр харилцан ашигтайгаар тохиролцож, хамтран ажиллана.





# АНХААРАЛ ХАНДУУЛСАН ТА БҮХЭНД БАЯРЛАЛАА